



МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/149

Улаанбаатар хот


Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүрэгт хамааралгүй асуудлын жагсаалт шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүрэгт хамааралгүй асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Хавсралтад дурдсан асуудлаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлж буй өргөдөл, гомдол, хүсэлтээр хяналт шалгалт, бусад үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг зогсоосугай.
3. Энэхүү тушаалыг улсын байцаагчдад танилцуулж, хэрэгжүүлж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хяналтын газрууд, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагуудын дарга нарт даалгасугай.
4. Тушаалыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлахыг Тамгын газар /Ч.Энхбат/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга /Д.Энхсайхан, Г.Сугарбат/ нарт үүрэг болгосугай.
5. Тушаал батлагдсантай холбогдуулан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүрэгт хамааралгүй асуудлын жагсаалт батлах тухай 2015 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 505 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Н.ЦАГААНХҮҮ



Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын
2017 оны 09 дугаар сарын 14-ны өдрийн
А/149 дугаар тушаалын хавсралт

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГТ
ХАМААРАЛГҮЙ АСУУДЛЫН ЖАГСААЛТ

НЭГ. НИЙТЛЭГ АСУУДЛААР

№	Өргөдөл, гомдол, албан бичгийн товч утга	Бусад агентлаг, эрх бүхий байгууллагууд шийдвэрлэх үндэслэл, тайлбар
1	Эрүүгийн, иргэний, захиргааны хэрэг маргаанд шинжээчээр ажиллах шүүгч, цагдаа, прокурорын шийдвэр	Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 9.1-т "Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх бол шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, хүсэлт гаргаж, шинжилгээ хийхээр томилогдож байгаа шүүхийн шинжилгээний байгууллагад ажилладаггүй шинжээчийг дуудан ирүүлж, түүний биеийн байцаалт, мэргэжил, чадвартай танилцан, сэжигтэн, яллагдагч, хохирогчтой ямар харилцаатай болохыг тогтоохоос гадна шинжээчээс татгалзан гарах үндэслэл байгаа эсэхийг шалгана" гэж заасан тул улсын байцаагч нь хувь хүнийхээ хувьд татгалзахгүй бол шинжээчээр ажиллаж болно. Мэргэжлийн хяналтын байгууллага нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.3.1-т "хууль тогтоомж болон нийтээр дагаж мөрдөх эрх зүйн бусад актын биелэлтэд хяналт тавих" үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг болно.
2	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагч шалгаж шийдвэрлэхээр зааснаас бусад зөрчлийг шалгуулахаар ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтны шалгах зөрчлийн харьяаллыг тогтоож өгсөн.

ХОЁР. ДЭД БҮТЦИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

№	Өргөдөл, гомдол, албан бичгийн товч утга	Бусад агентлаг, эрх бүхий байгууллагууд шийдвэрлэх үндэслэл, тайлбар
3	Тусгай зөвшөөрөл авах, сунгуулахын тулд улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах хүсэлт	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.

4	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчдийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлүүлэх хүсэлт	Тусгай зөвшөөрөл олгодог эрх бүхий байгууллагуудад хандаж асуудлыг шийдвэрлүүлнэ.
5	Байгууллагын удирдах ажилтан, албан тушаалтны ёс зүйн зөрчлийн тухай гомдол	Тухайн байгууллагын дотоод хяналтаар зохицуулагдана.
БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР		
6	Байгууллагын архивын өрөө тасалгаанд дүгнэлт гаргуулах хүсэлт	Архивын тухай хууль болон “Архивын байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм”-д заасны дагуу гал түймрийн хяналтын улсын байцаагч хяналт тавьж, дүгнэлт гаргана.
7	Орон сууц болон гадна хашааны галын аюулгүйн орц, гарц хаасан тухай гомдол	Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газар, аймгийн Засаг даргын Тамгын газар шийдвэрлэнэ.
8	Барилга байгууламжид төсөв санхүүгийн үнэлгээ гаргуулах хүсэлт	Хуулиар эрх олгогдсон мэргэжлийн үнэлгээний газрууд гүйцэтгэнэ.
9	Барилгын ажлын төсөв, гүйцэтгэл зохиолгох хүсэлт	Барилгын тухай хуулийн 24.2 дэх барилга байгууламжийн төсвийн тооцоог мэргэшлийн зэрэгтэй төсөвчнөөр хийлгэнэ.
10	Орон сууцны талбай хэмжүүлэх хүсэлт	Тусгай зөвшөөрөл бүхий зураг төслийн байгууллага “Хот байгуулалтын тухай”, “Барилгын тухай” хууль, “Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал MNS 6058:2009” стандартын дагуу хэмжилт хийнэ.
11	Импортоор оруулж ирсэн болон стандарт тогтоогдоогүй барилгын материал түүхий эд, халаалтын зуух, шалны халаалт бусад бараа бүтээгдэхүүнд дүгнэлт гаргуулах хүсэлт	“Стандартчилал тохирлын үнэлгээний тухай” хуулийн 16.4 дэх заалтын дагуу Стандартын болон оюуны өмчийн байгууллагууд хариуцна.
12	Хувийн болон амины орон сууцны барилга, тэдгээрийн инженерийн шугам сүлжээ, гараж, агуулах болон түр барилгын угсралт, засварын ажлын чанар байдалд дүгнэлт гаргуулах хүсэлт	Барилгын тухай хуулийн 10.1.1. /барилгын ажлын зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламж/ болон тус хуулийн 37.1.13-т заасны дагуу “Захиалагч нь барилгын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гарах эрсдэл, хохирлыг хариуцна”.
13	Орон сууцанд захиалга өгсөн иргэдийн гэрээ, төлбөр тооцоотой холбоотой гомдол	“Барилгын тухай хууль”-ийн 25-р зүйлд заасан Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүрэгт энэ асуудлыг тусгаагүй.
14	Байгууллага, аж ахуйн нэгжийг шагнах, урамшуулах, сонгон шалгаруулах зэрэгт тодорхойлолт, лавлагаа гаргах хүсэлт	Барилгын тухай хуулийн 47.2, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан чиг үүргийн дагуу хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ. Шагнал, урамшуулал, сонгон шалгаруулахтай холбоотой тодорхойлолт, лавлагаа өгөх асуудлыг тухайн салбарын төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНД ТАВИХ ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

15	<p>Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж, салхивч, ус, дулааны зангилааны хэвийн ажиллагаа доголдсон, дуу чимээ их, бөглөрсөн, эвдэрч ус алдсан, эвгүй үнэр үнэртдэг тухай</p>	<p>“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулийн 14.1.1-т “Хэрэглэгчийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжид үзлэг, шалгалт хийж заавар, зөвлөгөө өгөх”, 14.2.4-т “өөрийн ашиглалт, өмчлөлд байгаа инженерийн барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжид технологийн шаардлагын дагуу засвар, үйлчилгээ, шинэчлэлтийг тогтоосон хугацаанд нь хийх”, 15.1.8-т “өөрийн эзэмшилд байгаа шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах, засвар, үйлчилгээг хариуцан гүйцэтгэх”, 15.1.9-т “өөрийн эзэмшилд байгаа тоног төхөөрөмж, шугам сүлжээнд гэмтэл учруулсан бол шаардагдах засварыг өөрөө, боллоцоогүй бол хангагчаар хийлгэж, гарсан зардлыг төлөх”,</p> <p>“Барилгын тухай” хуулийн 46.1.4. “барилга байгууламжийн инженерийн хангамжийн системийг арчлан хамгаалах”,</p> <p>“Эрчим хүчний тухай” хуулийн 29.1.1, 29.1.3-т “гэрээнд заасан үйлчилгээний тввшинг хангах” заалтуудын дагуу тухайн барилгын инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон инженерийн шугам сүлжээний засвар, үйлчилгээний мэргэжлийн хангагч байгууллага хариуцан шийдвэрлэнэ.</p> <p>“Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн тухай хуулийн 15.1.1-т “орон сууцны байшингийн ...сууцны доторх дундын өмчлөлийн зүйл, тоног төхөөрөмж, ...тухайн орон сууцны дээрх болон доорх нийтийн зориулалттай усан сан, машины зогсоол, тэдгээртэй адилтгах байгууламж зэрэг эд хөрөнгө” хамаарна.</p> <p>БНБД-ийн 13-04-03-т заасан холбогдох заалтуудад үндэслэн эзэмшигч, ашиглагч, өмчлөгч, захиалагч, гүйцэтгэгч иргэн аж ахуйн нэгжүүд болон Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар, орон сууцны ашиглалт, засвар үйлчилгээний байгууллага /ОСНААК/, Сууц өмчлөгчдийн холбоо зэрэг байгууллагууд хариуцан шийдвэрлэнэ.</p>
16	<p>Инженерийн байгууламж шугам сүлжээнд хийгдсэн урсгал болон их засварын чанарт дүгнэлт гаргуулах, ус алдсан эвдрэлд акт тогтоолгох тухай</p>	<p>“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулийн 14.1.1-т. “хэрэглэгчийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжид үзлэг, шалгалт хийж заавар, зөвлөгөө өгөх”, 14.2.4-т “өөрийн ашиглалт, өмчлөлд байгаа инженерийн барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжид технологийн шаардлагын дагуу засвар, үйлчилгээ, шинэчлэлтийг тогтоосон хугацаанд нь хийх”,</p>

		<p>15.1.9-т “өөрийн эзэмшилд байгаа тоног төхөөрөмж, шугам сүлжээнд гэмтэл учруулсан бол шаардагдах засварыг өөрөө, бололцоогүй бол хангагчаар хийлгэж, гарсан зардлыг төлөх;”,</p> <p>БНБД 13-04-03-н холбогдох заалтуудын дагуу Инженерийн тухайн шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг хариуцсан мэргэжлийн байгууллагын шийдвэрийг үндэслэн эзэмшигч, ашиглагч, захиалагч, гүйцэтгэгч нар иргэн аж ахуйн нэгж байгууллагууд хариуцна.</p> <p>Орон сууцны тухай, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн тухай” хуулиудын холбогдох заалтын дагуу хяналт тавина. Орон сууцанд ус алдсан бол харъяа ОСНААКонторын даргын тушаалаар томилогдсон “Хохирол тогтоох комисс” акт тогтооно.</p>
--	--	---

АВТО ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

17	Нийтийн зорчигч тээвэр, ачаа тээврийн хэрэгслээр үйлчлүүлсэн тээврийн хэрэгслийн үнэ тарифын асуудлаар ирсэн санал, гомдол	Авто тээврийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтын дагуу ЗТЯ, ОБЕГ бусад холбогдох байгууллагууд шийдвэрлэнэ.
18	Импортоор оруулж ирсэн болон стандарт тогтоогдоогүй шинэ, хуучин тээврийн хэрэгсэл, сэлбэг материалын хийц бүтээцийн чанар, автомашины хөдөлгүүрийн тос, тосолгооны материал, хөдөлгүүрийн болон түлшний нэмэлт бүтээгдэхүүн, төхөөрөмжид дүгнэлт гаргуулах тухай хүсэлт	Стандартчилал тохирлын үнэлгээний тухай хуулийн 16.4 дэх заалтын дагуу баталгаажуулалтын байгууллага тохирлын гэрчилгээ олгоно. Автотээврийн болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хуулиар эрх олгогдсон техникийн хяналтын үзлэг, оношилгоо, туршилт явуулах эрхтэй мэргэжлийн байгууллага дүгнэлт гаргана.
19	Тээвэрлэлтийн болон тээврийн хэрэгсэл, сэлбэг материал нийлүүлэх талаарх гэрээ, гэрээний үүргийн биелэлтийн талаарх маргаантай холбогдсон асуудалд дүгнэлт гаргуулах хүсэлт	Иргэний тухай хуулийн дагуу шүүх болон хуулийн байгууллага шийдвэрлэнэ.
20	Автотээврийн хэрэгслийн сэлбэг, материалын үнэ, засвар үйлчилгээний ажлын хөлс, чанаргүй сэлбэг материал худалдаж авсан талаарх санал, гомдол	Автотээврийн тухай хуулиар хяналт тавих эрх зүйн зохицуулалт байхгүй. ШӨХТГ нь үнийн зохицуулалттай холбоотой асуудлыг, ХЭАХН болон тухайн худалдан борлуулсан үйлчилгээний газрууд бүтээгдэхүүнийхээ чанар, аюулгүй байдлыг хариуцна.
21	Авто машинд үүссэн эвдрэл гэмтэлд дүгнэлт гаргуулах хүсэлт	Техникийн хяналтын үзлэг оношилгоо хийх эрх бүхий байгууллага шалгаж, дүгнэлт гаргана.
22	Төрийн болон хувийн өмчийн байгууллагын эд хөрөнгө, автотээврийн хэрэгслийг актлах тухай дүгнэлт гаргуулах хүсэлт	Автотээврийн мэргэжлийн байгууллага ТӨХ-ны 2012 оны “Эд хөрөнгийн харилцааг зохицуулах журмын шинэчилсэн найруулгыг батлах тухай” 44-р тогтоолын 1.9-ын” г”-д заасны дагуу акт, дүгнэлт

		гаргана.
23	Шинээр үйлдвэрлэгдсэн болон ашиглалтанд орох тээврийн хэрэгсэл, түүний сэлбэг материалын хийц бүтээцийн чанарт дүгнэлт гаргуулах	Автотээврийн болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хуулиар эрх олгогдсон техникийн хяналтын, туршилтын ажил эрхлэх мэргэжлийн байгууллага хариуцна.
ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР		
24	Зам талбайн гэрэлтүүлгийн хариуцсан байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой гомдол	Эрчим хүчний тухай хуулийн “Хяналт, хариуцлага” зургадугаар бүлэг, 34.1.1 дэх заалт, тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.11 дүгээр заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дах, 25-р зүйл, 30-р зүйл, “Хэрэглэгчийн эрх, үүрэг”-ийн 30.1.1; 30.1.3; 30.1.7; 30.1.8; 30.2 дугаар заалтын дагуу эзэмшигч өөрсдөө хяналт тавина.
25	Дулаан, цахилгаан, усны, харилцаа холбооны үнэ тариф, өртөг зардал, төлбөр тооцоог хянуулах тухай гомдол, хангагч хэрэглэгчдийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлүүлэх хүсэлт	Эрчим хүчний зохицуулах хороо Эрчим хүчний тухай хуулийн 9.1.4-т заасны дагуу дулаан цахилгааны үнэ тарифыг тогтооно. Зохицуулах зөвлөл Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухайхуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтаар цэвэр бохир усны үнэ тарифыг тогтооно. Эрчим хүчний тухай хуулийн 35.1-т Эрчим хүчний зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэнэ.
26	Техникийн нөхцөл олгогдоогүй тул хангагч эх үүсвэрийн хүчин чадал хүрэлцэх эсэхэд дүгнэлт гаргуулах хүсэлт	Техникийн нөхцөл олгох эрх бүхий байгууллага тооцоо хийж холбох боломжтой эсэхийг тогтооно.
27	Хүчдэлийн хэлбэлзлээс иргэдэд учирсан хохиролд акт гаргуулах хүсэлт	Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн 10.49 дэх заалтын дагуу цахилгаан эрчим хүч тасалснаас болон чанарын үзүүлэлтийн хэлбэлзлээс үүссэн хохирлыг тогтоохдоо хэрэглэгч дээр тавигдсан хэмжих хэрэгсэл болон түгээгчийн шуурхай ажиллагааны бичлэгийг баримтлан хангагч, хэрэглэгчийн хамтран үйлдсэн актыг үндэс болгоно.
28	Ахуйн хэрэглээний багаж, тоног төхөөрөмж /халаагуур, тень, шалны халаалт, хөдөлгүүр/-д дүгнэлт гаргуулах тухай хүсэлт	Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Баталгаажуулалтын байгууллага нь зохих журмын дагуу баталгаажуулалтад тэнцсэн гадаадын болон дотоодын аж ахуйн нэгж, байгууллагын бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгоно” гэж заасны дагуу Стандартчилал хэлжилзүйн газарт хандаж шийдвэрлүүлнэ.
29	Иргэний тэжээвэр амьтан, мал хүчдэлд нэрвэгдэж үхсэн хохирлыг барагдуулах тухай хүсэлт	Иргэний журмаар шүүхэд хандаж хохирлоо барагдуулна.

30	Цахилгаан эрчим хүчний хэрэглээг тооцож байгаа цахилгааны тоолуурыг эвдэлсэн хохирлыг шалгуулах тухай хүсэлт	Эрчим хүчний тухай хуулийн 30.1.7-т заасны дагуу хэрэглэгч нь эрчим хүчний тоолуур, хэмжүүрийн бүрэн бүтэн байдлыг хариуцах үүрэгтэй. Шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагад хандана.
ГАЗРЫН ТОС, ШИНГЭРҮҮЛСЭН ШАТДАГ ХИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР		
31	Шатахууны чанараас шалтгаалж автомашинд гарсан эвдрэл, гэмтэлд дүгнэлт гаргуулах тухай хүсэлт	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 8.4.2, 9.3.7-т заасны дагуу газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгч нь газрын тосны бүтээгдэхүүний чанарын шинжилгээ, туршилт хийх итгэмжлэгдсэн лабораторитой байна. Эвдрэл гэмтлийг оношлогооны төвүүд тодорхойлно.
АВТО ЗАМЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР		
32	Авто зам, замын байгууламжид төсөв санхүүгийн үнэлгээ гаргуулах хүсэлт	Хуулиар эрх олгогдсон мэргэжлийн үнэлгээний газрууд гүйцэтгэнэ.
ХЭМЖИЛ ЗҮЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР		
33	Хэмжих хэрэгслийн заалт авалт, заалтаар тооцож буй үнэ тариф, өртөг зардал, төлбөр тооцоог хянуулах тухай хүсэлт, гомдол, хангагч, хэрэглэгчдийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлүүлэх	Эрчим хүчний тухай хуулийн 9.1.4, 35.1 дэх заалт, Хот суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10.1.1 дэх заалтын дагуу Эрчим хүчний зохицуулах хороо, аймаг нийслэлийн Зохицуулах зөвлөл, Хот суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг хариуцсан байгууллага тус тус хяналт тавьж, шийдвэрлэнэ.
34	Хэмжих хэрэгсэл үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах, сунгахын тулд улсын байцаагчаас тодорхойлолт, дүгнэлт гаргуулах тухай хүсэлт	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР		
35	Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний үнэ тариф, төлбөр тооцоотой холбоотой гомдол, хүсэлт	Харилцаа холбооны тухай, Өрсөлдөөний тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо, ШӨХТГ-ын эрх үүрэгт хамаарна.
36	Радио долгионы үүсгэх цахилгаан соронзон оронгийн хүний биед үзүүлэх нөлөөллийн талаар дүгнэлт гаргуулах хүсэлт	Радио долгионы тухай хуулийн дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны Радио давтамж хяналт зохицуулалтын албанаас хэмжилт хийж, холбогдох дүгнэлтийг гаргана.
37	Нийтийн орон сууц болон нийтийн эзэмшлийн газарт байрлуулсан үүрэн холбооны станцын радио тоног төхөөрөмжөөс үүсэх	Харилцаа холбооны зохицуулах хороо, Радио давтамж хяналт зохицуулалтын алба Радио долгионы тухай хуулийн 20 дугаарт заасны дагуу хэмжилт хийнэ.

	цахилгаан соронзон оронгийн хүний биед үзүүлэх нөлөөллийн талаар дүгнэлт гаргуулах хүсэлт	
38	Төсөл хөтөлбөрийн албан хэрэгцээнд ашиглаж байсан компьютер болон бусад техник хэрэгслийн эвдрэл гэмтлийн талаар дүгнэлт гаргуулах хүсэлт	Мэргэжлийн хяналтын байгууллагад хуулиар эрх олгогдоогүй.

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

№	Өргөдөл, гомдол, албан бичгийн товч утга	Бусад агентлаг, эрх бүхий байгууллагууд шалгах үндэслэл, тайлбар
ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР		
39	Их цэвэрлэгээ зохион байгуулах	“Хог хаягдлын тухай” хуулийн 9.5.2-т нутаг дэвсгэртээ байгаа хог хаягдлыг цэвэрлэх зайлуулах ажилд иргэдийг татан оролцуулах ажлыг Баг, хорооны засаг даргын эрх үүргийн хүрээнд шийдвэрлэнэ.
ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР		
40	Газар эзэмшигч иргэн, хуулийн этгээд хоорондын газрын маргааныг шийдвэрлүүлэх хүсэлт	Газрын тухай хуулийн 60-р зүйлд заасны дагуу тухайн шатны болон дээд шатны Засаг дарга, шүүх, газрын алба шийдвэрлэнэ.
41	Нийтийн эзэмшлийн зам талбай, орц гарцыг чөлөөлүүлэх	Газрын тухай хуулийн 56.4-д заасан “Хот тосгон бусад суурингийн доторх бусдын эзэмшил ашиглалтад олгогдоогүй газрыг тухайн шатны Засаг дарга шийдвэр гаргаж газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу ашиглалтын зориулалт, ашиглаж эхлэх хугацаа бусад нөхцөл шаардлагуудыг бичсэн дохио, санамж тавих, хашаа, хайс татах, сахиул ажиллуулах зэргээр хамгаалалтад авах” эрхтэй тухайн шатны Засаг даргын эрх үүргийн хүрээнд шийдвэрлэнэ.
42	Зөвшөөрөлгүй эзэмшиж ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн газар чөлөөлүүлэх, “газар чөлөөлүүлэх тухай”, “газар албадан чөлөөлөх тухай” Захирамжийн хэрэгжилтийг хангуулах тухай хүсэлт	Газрын тухай хуулийн 57.3-т зохих зөвшөөрөлгүйгээр газар дээр барилга, байгууламж барьсан, эсхүл бусад хэлбэрээр түүнийг дур мэдэн эзэмшсэн бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга уг газрыг чөлөөлөх хугацаатай мэдэгдэл өгнө. 57.4-т мэдэгдэлд заасан хугацаанд газрыг чөлөөлөөгүй бол аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга уг газрыг албадан чөлөөлөх арга хэмжээ авч, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулна. 59.1.1-т “хууль, гэрээнд заасан үндэслэлээр газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болсон, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр газар эзэмшсэн, ашигласан бол албадан нүүлгэх тухай Засаг даргын шийдвэрийн биелэлтийг хангах” эрх үүргийн

		хүрээнд Цагдаагийн байгууллага шийдвэрлэнэ.
ХИМИЙН БОДИСЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР		
43	Химийн хорт бодисын улсын үзлэг тооллого хийлгүүлэх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 6.1.8-т “химийн хорт болон аюултай бодис ашигласан үйл ажиллагааны нэгдсэн тайланг жил бүр гаргах үүрэгтэй.”
УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР		
44	Ус ашиглах зөвшөөрөл хүсэх тухай	“Усны тухай” хуулийн 28.1-т заасны дагуу ашиглах хэмжээнээс хамаарч төрийн захиргааны төв байгууллага, сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны албанд ус ашиглах хүсэлтээ “Усны тухай” хуулийн 28.2-т заасны дагуу гаргана.
45	Ашиглалтгүй болсон бохирын цооног буулгуулах хүсэлт	Усны тухай хуулийн 22.17.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашиглаж дууссан цооноогоо битүүмжлэн аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэж өгнө.
46	Бохир, хаягдал ус зайлуулах тухай гомдол	Усны тухай хуулийн 17.1.9-т “Ус ашиглах, хаягдал ус зайлуулах шаардлагыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах, хаягдал ус зайлуулах эрхийг цуцлах дүгнэлт гаргах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргана, 18.1.3-т “Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, усан орчинг нөхөн сэргээх, ус хангамж, ариутгах татуургын болон хаягдал ус зайлуулах үйл ажиллагаанд хяналт тавих”-аар заасны дагуу аймаг, нийслэлийн Байгаль орчны алба хяналт тавьж, Сав газрын захиргаад ус зайлуулах эрхийг цуцлах, нэхэмжлэл гаргах зэрэг асуудлыг хариуцан шийдвэрлэнэ.
47	Ус ашиглах дүгнэлт гаргуулах тухай хүсэлт	Ус ашиглагчид нь “Усны тухай” хуулийн 28.4 дэх заалтад /Хоногт 100 шоо метрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоо метр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоо метр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн Байгаль орчны алба тус тус гаргана. Иймд үйл ажиллагааны хүчин чадлаас хамаарч ус ашиглах дүгнэлтийг холбогдох газруудад хандаж гаргуулна.
БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР		
48	Байгаль орчинд нөлөөлөх байдлын	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7.5-т

	үнэлгээ хийлгэх	заасан шаардлагыг хангасан тусгай зөвшөөрөлтэй Монгол Улсын аж ахуйн нэгж байгууллага байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийнэ.
49	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ/цаашид БОНБУ гэх/-нд санал авах	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.5-т заасны дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд төсөл хэрэгжүүлэгчээс албан ёсоор санал авна.
50	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн тухай дүгнэлт гаргуулах хүсэлт	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.13-т шаардлагатай тохиолдолд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын шийдвэрээр байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэл болон энэ хуулийн 9.12-т заасан хяналтын дүнд хөндлөнгийн хяналт хийж, дүгнэлт гаргах бөгөөд уг ажилд шаардагдах зардлыг төсөл хэрэгжүүлэгч хариуцна. 15.1.3-т байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүнг тусган боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд төслийг үргэлжлүүлэх эсэх талаарх дүгнэлтийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тавина.
51	Тусгай зөвшөөрөлтэй талбайн алт угааж байсан газруудаас хүнд металлын агууламжийг тодорхойлуулах тухай аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 16.1.1-т БОНБНУ хийсэн аж ахуйн нэгж, байгууллага нь урьд хийгдсэн шинжилгээ, судалгааны дүгнэлтийг ашиглаж түүнийг тодотгох холбогдох чиглэлээр нэмэлт судалгаа хийх үүрэгтэй.
52	Уурхайн үйлдвэрлэлийн шингэн хаягдлын далангийн хөрс болон далд уурхайн шавхалтын уснаас дээж авч шинжилгээ хийлгэх тухай аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 16.1.1-т БОНБНУ хийсэн аж ахуйн нэгж, байгууллага нь урьд хийгдсэн шинжилгээ, судалгааны дүгнэлтийг ашиглаж түүнийг тодотгох холбогдох чиглэлээр нэмэлт судалгаа хийх үүрэгтэй.
УУЛ УУРХАЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР		
53	Үйл ажиллагаа эхлэх зөвшөөрөл авахад шаардагдах материалыг гаргаж өгөх тухай аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэнд хяналт тавих тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар санал дүгнэлт гаргах үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлөөс зөвшөөрөл авна.
54	Хайгуулын тайлангийн тодорхойлолт гаргуулах хүсэлт	Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас /Ашигт малтмал, газрын тосны газар/ хайгуулын тайлангийн тодорхойлолтыг гаргуулна.
55	Аж ахуйн нэгж, байгууллагын шинжилгээ хийлгүүлэх тухай	"Ашигт малтмалын тухай" хуулийн 11.1.8-д "уул уурхайн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа техник,

	хүсэлт	технологид үнэлэлт, дүгнэлт өгөх, техник, технологийн бодлогыг хэрэгжүүлэх;" чиг үүргийн дагуу Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хамааралтай.
56	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайн хилийн маргааныг шийдвэрлүүлэх хүсэлт	"Ашигт малтмалын тухай" хуулийн 11.1.21; 11.1.23; 62.1-т "Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд үүссэн талбайн хилийн маргааныг төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.
57	Байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлээгүй тухай тодорхойлолт гаргуулах хүсэлт	Хууль тогтоомжоор Мэргэжлийн хяналтын байгууллагад эрх олгоогүй.

**ГУРАВ. ХӨДӨЛМӨР, ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙ, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР**

№	Өргөдөл, гомдол, хүсэлт, албан бичгийн товч утга	Бусад агентлаг, эрх бүхий байгууллагууд шалгах үндэслэл, тайлбар
58	Өндөр насны тэтгэвэр тогтооход хөдөлмөрийн нөхцөлийн тодорхойлолт гаргуулах тухай иргэдийн хүсэлт	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалаар баталсан "Тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт"-ын 4-т "Хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа болон ажиллаж байсан ажилтны нийгмийн даатгалын дэвтэрт бичигдсэн ажил мэргэжлийн нэр ажил олгогчийн буруугаас энэхүү жагсаалттай зөрчилдсөний улмаас тэтгэвэр тогтоолгох асуудлаар гарч буй гомдол маргаан, гарсан саналын зөрөөг Нийгмийн даатгалын байгууллагын дэргэдэх гомдлын шаардлагын зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэж байхыг Нийгмийн даатгалын байгууллагад даалгасан байдаг тул тус байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.
59	Хүнсний дэлгүүр, цайны газар, бар ресторан, үсчин, гоо сайхан, халуун ус, биллъярдын газар, тураах төвд ажлын байрны дүгнэлт гаргуулах аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт	Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 325 дугаар тогтоолоор хүчингүй болгосон тул харъяа нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын газар/хэлтэст хандаж эсхүл inspection.gov.mn хаягаар бүртгүүлнэ.
60	Ажлаас халагдсан тухай гомдол	Хөдөлмөрийн тухай хуулийн 128.1-т заасны дагуу шүүх шийдвэрлэнэ.

ДӨРӨВ.ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

№	Өргөдөл гомдол албан бичгийн товч утга	Бусад агентлаг эрх бүхий байгууллагуудын хууль тогтоомжоор олгогдсон эрх үүрэгтэй холбоотой

ХҮНСНИЙ ЧАНАР, СТАНДАРТЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР		
61	<ul style="list-style-type: none"> • мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, • өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, • нярай, бага насны болон цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэлээс бусад ажлын байранд улсын байцаагчийн дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн аж ахуйн нэгж, иргэдийн хүсэлт 	<p>Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон Засгийн газрын 325-р тогтоолоор хүчингүй болсон тул харъяа нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын газар/хэлтэст хандаж эсхүл fsi.gov.mn хаягаар бүртгүүлнэ.</p> <p>Согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүсэх, сунгахад харьяа нутаг дэвсгэрийн худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэст хандаж шийдвэрлүүлнэ.</p>
62	Худалдаа, үйлчилгээний газруудын ажиллах цагийн хуваарийн байдалд шалгалт хийлгүүлэх хүсэлт	Цагдаагийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.
63	Нийтийн орон сууцанд байрлах хүнсний чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний газрын засварын ажил, түүний дуу чимээ гаргаж байгаад шалгалт хийлгүүлэх тухай гомдол	Сууц өмчлөгчдийн холбоо “СӨХ-ны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн тухай” хуулийн 15.1.1-т заасны дагуу дундын өмчлөлд хяналт тавина.
64	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд дүгнэлт гаргуулах хүсэлт	“Хүнсний тухай” хуулийн 10.1.1 “хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа үр дагаврыг өөрөө хариуцах”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн 5.1.2 “хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ аюулгүй байдлыг хариуцах”, 10.1.6 “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох болон дотоод хяналт, шалгалтын бүртгэл, тэмдэглэл, тайлан тооцоо, лабораторийн шинжилгээний хариу зэрэг мэдээлэл болон баримт бичгийг хадгалах” үүрэгтэй тул Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагч дүгнэлт гаргахгүй.
65	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн аж ахуйгаас бэлтгэсэн мах, сүүний чанар, аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах хүсэлт	
66	Үйлчилгээний соёл, зан харьцаатай холбоотой гомдол	“Хүнсний тухай” хуулийн 10.1.1-т үйл ажиллагаа эрхлэгч нь үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, сөрөг үр дагаврыг өөрөө хариуцахаар заасан.
67	Зочид буудал дуу чимээ ихтэй, архи зардаг, архиддаг асуудлыг шалгуулах гомдол	Цагдаагийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

68	Бараа, бүтээгдэхүүний лангуун дээрх үнэ нь кассын үнийн дүнгээс зөрсөн гомдол	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт хандаж шийдвэрлүүлнэ.
69	Хугацаа дууссан бараагаа худалдагчаар төлүүлдэг тухай гомдол	Шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.
70	Үйлчилгээний шаардлага хангахгүй байгаа тул мөнгөө буцааж гаргуулах гомдол	Шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.
71	Зар сурталчилгаанд хяналт тавиулах хүсэлт	Зар сурталчилгааны тухай хуулийн 24.1-т “Монгол Улсын нутаг дэвсгэрт зар сурталчилгаанд тавих хяналтыг оюуны өмчийн улсын хяналтын алба хэрэгжүүлнэ”
72	Зах зээлийн өрсөлдөөнтэй холбоотой асуудлыг шалгуулах хүсэлт	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавина.
73	Иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах, эрхээ хамгаалуулах зорилгоор ирүүлсэн гомдол	Оюуны өмч, улсын бүртгэлийн газар нь Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавина.

МАЛ ЭМНЭЛЭГ, ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

74	Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээ эрхлэгчдэд тусгай зөвшөөрөл олгоход дүгнэлт гаргуулах хүсэлт	Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 57 дугаар тогтоолоор хүчингүй болгосон тул харъяа нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын газар/хэлтэст хандаж эсхүл fsi.gov.mn хаягаар бүртгүүлнэ.
75	Мал эмнэлгийн лабораторит ажлын байрны дүгнэлт гаргуулах хүсэлт	Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 13.3-т “итгэмжлэлийг улсын хэмжээнд Стандартчиллын төв байгууллага эрхлэн гүйцэтгэнэ”, 13.6.1-т “итгэмжлэлийн техникийн хорооны дүгнэлтийг үндэслэн итгэмжлэлийн гэрчилгээ олгоно”; 13.6.4-т “итгэмжлэгдсэн сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд магадлан шалгалт хийх” гэж заасны дагуу Стандартчиллын төв байгууллага итгэмжилнэ.
76	Жижиг амьтны мал эмнэлэг ажиллуулах, малын эмийн сан, шувууны аж ахуйн ажлын байрны дүгнэлт гаргуулах хүсэлт	Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 325 дугаар тогтоолоор хүчингүй болгосон тул харъяа нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын газар/хэлтэст хандаж эсхүл fsi.gov.mn хаягаар бүртгүүлнэ.
77	Гэрийн тэжээвэр амьтнаас иргэдийн тав, тухыг алдагдуулсан тухай гомдол, хүсэлт	Мэргэжлийн хяналтын албаны эрх үүрэгт /Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуульд тусгагдаагүй/ хамааралгүй болно.

УРГАМАЛ ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР		
78	Ургамлын харшлаас хамгаалах, шарилж, хог ургамалтай тэмцэх бүх нийтийн их цэвэрлэгээг эрчимжүүлэх	“Хог хаягдлын тухай” хуулийн 8.4.4-д нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлүүлэх, хяналт тавихыг Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэнэ. Энэ үйл ажиллагаа нь ТХШТХ-ийн 31.1.1-д “хяналт шалгалт” гэж тодорхойлолтод тусгагдаагүй, хяналт шалгалтын объект биш тул Мэргэжлийн хяналтын байгууллагад хамааралгүй болно.
79	Хор шүршигч техникийн үйл ажиллагааны талаарх гомдол	Байгууллагын дотоод хяналт шалгалтаар хяналт тавьж шийдвэрлэнэ.

ТАВ. ХИЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

80	Нялх, балчир хүүхдийн хүнсний бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн, өндөг, архи согтууруулах ундаа, тамхин бүтээгдэхүүнээс бусад импортлох хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хүсэлтээр дүгнэлт гаргуулах	Хүнсний тухай хуулийн 10.1.1 “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа үр дагаврыг өөрөө хариуцах”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн 5.1.2 “хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний өөрт хамаарах үе шатанд хүнсний аюулгүй байдлыг хариуцах”, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.1.6-т “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох болон дотоод хяналт шалгалтын бүртгэл, тэмдэглэл, тайлан тооцоо, лабораторийн шинжилгээний хариу зэрэг мэдээлэл болон баримт бичгийг хадгалах” үүрэгтэй тул импортын хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг тухайн импортлогч хариуцна.
81	Эрсдэл багатай ангилалд хамаарсан импортын бараанд дүгнэлт гаргуулах аж ахуйн нэгжийн хүсэлт	Эрүүл ахуйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 заалтыг үндэслэн хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөө үзүүлэхгүй, бага эрсдэлтэй импортын бараанд Мэргэжлийн хяналтын байгууллагаас дүгнэлт гаргахгүй.
82	Сурагчийн дүрэмт хувцас, цэнэглэгч хуруу батерей, угаалгын нунтаг, салфетка зэрэг ахуйн болон өдөр тутмын хэрэглээний импортын барааг хуурамч байна гэсэн гомдол	Барааны хуурамч байх асуудал нь мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4, 16.1.6-д заасны дагуу хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах төрийн захиргааны байгууллага /ШӨХТГ/-д хамаарна.

ЗУРГАА.ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

№	Өргөдөл, гомдол, албан бичгийн товч утга	Бусад агентлаг, эрх бүхий байгууллагууд шалгах үндэслэл, тайлбар
83	Эмчилгээний төлбөр, нэхэмжилсэн төлбөр мөнгөтэй холбоотой гомдол	Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн нэгдүгээр хэсгийн 43.1-т “Гэмт хэргийн улмаас учирсан эд

		хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн, түүнийгээ нөхөн төлүүлэх буюу сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа иргэн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ”, тус хуулийн хэрэгжилтэд 8.1-т заасан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахдаа мөрдөнө.
84	Эрүүл мэндийн байгууллагын ажлын байрны дүгнэлт гаргуулах хүсэлт	Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 325 дугаар тогтоолоор хүчингүй болгосон.
85	Эм, биобэлдмэл, вакцин, оношлуур, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгслийг импортлох, үйлдвэрлэхэд бүтээгдэхүүний дүгнэлт гаргуулах хүсэлт	Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 325 дугаар тогтоолоор хүчингүй болгосон.
86	<ul style="list-style-type: none"> • Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, • өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, • нярай, бага насны болон цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэл бусад ажлын байранд улсын байцаагчийн дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн аж ахуйн нэгж, иргэдийн хүсэлт	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон Засгийн газрын 325-р тогтоолоор хүчингүй болсон тул харъяа нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын газар/хэлтэст хандаж эсхүл fsi.gov.mn хаягаар бүртгүүлнэ.
87	Өвчний улмаас ЕБС-ийн элсэлтийн шалгалтанд орох боломжгүй болсон тухай баталгаа гаргуулах хүсэлт	Эрүүл мэндийн байгууллагуудад хандаж шийдвэрлүүлнэ.
88	Сурагч хичээлээс чөлөөлөгдсөн нь үндэслэлтэй эсэхэд баталгаа гаргуулах хүсэлт	Эрүүл мэндийн байгууллагуудад хандаж шийдвэрлүүлнэ.
89	Зочид буудал, саун, ажлын хувцасны дэлгүүр, биллъярдад ажлын байрны дүгнэлт гаргуулах хүсэлт	Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 325 дугаар тогтоолоор хүчингүй болгосон.
90	РС тоглоомын газар 24 цагаар ажиллаад байгааг шалгуулах гомдол	Цагдаагийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.
91	Мансууруулах сэтгэц нөлөөт эмийн агуулахын байранд дүгнэлт гаргуулахаас бусад эм хангамжийн байгууллагын ажлын байранд дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн өргөдөл, хүсэлт	МУ-ын ЗГ-ын 2010 оны 325 дугаар тогтоолоор хүчингүй болсон.

92	Үйл ажиллагаа нь эхэлсэн барилга байгууламжийн газар олголт, зураг төсөлд эрүүл ахуйн дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн өргөдөл, хүсэлт	Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт газар олголт хийгдэх, барилга байгууламж баригдахаас өмнө урьдчилан хянахаар заасан байдаг.
----	---	--

ДОЛОО. ЦӨМ, ЦАЦРАГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

№	Өргөдөл, гомдол, албан бичгийн товч утга	Бусад агентлаг, эрх бүхий байгууллагууд шалгах үндэслэл, тайлбар
93	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжид баталгаажилт хийлгэх хүсэлт	Ионжуулагч цацрагийн үүсгүүртэй рентген тоног төхөөрөмжөөс бусад эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн хэмжилт, баталгаажилтыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба гүйцэтгэнэ.
94	Гоо сайхны /лазер/ багаж, төхөөрөмжид дүгнэлт гаргуулах хүсэлт	Эрх зүйн орчин байхгүй. Эмчилгээний гоо сайхан, мэс ажилбар хийгдэхэд ашиглагддаг аппарат хэрэгслийн хувьд асуудлыг Эрүүл мэндийн яаманд тавьж шийдвэрлүүлнэ.
95	Хэт ягаан эсвэл хэт улаан туяаны үйлчлэлтэй аппарат, төхөөрөмжид дүгнэлт гаргуулах хүсэлт /Аппаратыг эмнэлгийн бус нөхцөлд хүний эрүүл мэндэд тустай гэж хэрэглүүлэх хүсэлт/	Эмнэлгийн бус багаж, тоног төхөөрөмж тул Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт шалгалтанд хамаарах, эрх зүйн орчин байхгүй.
96	Хаягдал лааз, хуванцар материалыг экспортлож буй аж ахуйн нэгж, байгууллагууд цацрагийн тунгийн хэмжээг тогтоолгож улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах хүсэлт	Тус бүтээгдэхүүнд цацрагийн тунгийн хэмжээг тогтоох, дүгнэлт гаргах хууль, эрх зүйн заалт байхгүй. Мөн Олон Улсын Атомын Энергийн Агентлагаас гаргасан хяналтад үл хамааруулах, хяналтаас чөлөөлөх түвшиний аюулгүй ажиллагааны зөвлөмж (IAEA RS-G-1.7 Application for the Concepts of Exclusion, Exemption and Clearance)-д цацрагийн хяналтаас чөлөөлөх боломжтой гэж үздэг.

НАЙМ. БОЛОВСРОЛЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

№	Өргөдөл, гомдол, албан бичгийн товч утга	Бусад агентлаг, эрх бүхий байгууллагууд шалгах үндэслэл, тайлбар
97	Төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн сургалтын төлбөрийн тухай гомдол	“Боловсролын тухай” хуулийн 35.4.8-т “Сургууль, цэцэрлэгийн зөвлөл нь сургалтын төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу тогтооно” гэж заасны дагуу сургууль, цэцэрлэгийн зөвлөлд хандаж болно. Мөн хуулийн 45.1.7-т суралцагч нь “сургалтын төлбөр, хандивын зарцуулалт, ашиглалтын талаар мэдээлэл авах, хяналт тавина” гэж заасны дагуу тухайн иргэн сургалтын төлбөрийн зарцуулалтын талаар бүрэн мэдээлэл авч, хяналт тавина. 14.1-т Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн биелэлтэд

		хяналт тавих, өрсөлдөөний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, аж ахуй эрхлэгч, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага тул тус байгууллагад хандан шийдвэрлүүлж болно.
98	Хүүхдийн зуслангийн багшийн болон сургалт хүмүүжлийн ажилтай холбоотой гомдол /хоол, орчны эрүүл ахуй, халдвар хамгааллын асуудал хамаарахгүй/	Хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар энэ асуудлаар хяналт тавина. Харин хүүхдийн зуслангийн хоол, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтөд Мэргэжлийн хяналтын байгууллагын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч хяналт тавина.
99	Боловсролын хяналтын чиглэлээр багш, ажилчдыг хууль бусаар ажлаас халсан, чөлөөлсөн маргаан	Хөдөлмөрийн тухай хуулийн 128 дугаар зүйлд заасан шүүхэд харъяалагдах маргаан болно.
100	Хүний амь нас, эрүүл мэнд, алдар хүнд, нэр төртэй холбоотой маргаан	Иргэний хуулиар хуулийн /шүүх, цагдаа/ байгууллагад хамааралтай.
101	Ажилтны мэргэжил, ур чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй талаарх дүгнэлт гаргуулах хүсэлт, өргөдөл, маргаан	Улсын дээд шүүхийн 33-р тогтоолын 15.2 "...гэдгийг ажилтны энэ байдлын талаар салбарын буюу тухайн байгууллагын мэргэжил, ур чадварын түвшин тогтоох комисс, аттестатчиллын комисс болон, эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын албан ёсны дүгнэлт, шийдвэр гарсан байхыг ойлгох" тул дурдсан байгууллагуудад хандаж шийдвэрлүүлнэ.
102	Эрх бүхий хууль, хяналтын болон төрийн байгууллагын хүсэлтээс бусад тохиолдолд их, дээд сургууль, коллеж төгссөн талаарх боловсролын баримт бичигтэй холбоотой лавлагаа авах иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт	БСШУ-ны сайдын 401-р тушаалаар батлагдсан Дээд боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрмийн 4.10-т дээд боловсролын сургалтын байгууллага нь "Сургууль суралцагчийн суралцсан байдлын талаар холбогдох мэдээ, нотолгоог суралцагчийн хүсэлтээр саадгүй гаргаж өгөх үүрэгтэй" тул тухайн сургуульд нь хандаж шийдвэрлүүлнэ.
103	Цэцэрлэг байгуулахад улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах хүсэлт	Боловсролын тухай хуулийн 22.1.4, 22.1.5, 22.1.6-т заасны дагуу шинжээч дүгнэлт гаргана.
104	Төрийн албан ёсны хэлний мэдлэгийг эзэмшүүлэхгүй байгаа асуудлаар ирсэн өргөдөл, гомдол	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8-р зүйлийн 6.16-т заасны дагуу Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчид хандана.
105	Хүүхдийн сурч боловсрох, хөгжих, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хязгаарласан тухай, сургууль, сургуулийн дотуур байр, тэдгээрийн гаднах орчинд сурагч бусад сурагчийг дарамталж, зүй	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8-р зүйлийн 6.26-т заасны дагуу хүүхдийн эрхийн улсын байцаагчид хандана. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8-р зүйлийн 6.8-т Цагдаагийн байгууллагын эрх бүхий

	бусаар харьцаж сургуульд суралцах боломжгүй байдлыг бий болгосон тухай өргөдөл, гомдол	албан хаагчид хандана.
106	Хүүхэд харах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагыг зөрчсөн, эсхүл хориглосон үйл ажиллагааг явуулсан тухай, Хүүхэд харах үйлчилгээний зохион байгуулалтын талаархи журам зөрчсөн, эсхүл хүүхэд харагч хуульд заасан үүргээ биелүүлээгүй тухай өргөдөл, гомдол	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8-р зүйлийн 6.26-т заасны дагуу хүүхдийн эрхийн улсын байцаагчид хандана.
107	Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны асуудлаар ирсэн өргөдөл, гомдол	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8-р зүйлийн 6.22-т заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчид хандана.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР